


**Улаанбаатар хотын хүйтний улирлын агаарын чанарын төлөв байдал
/2017 оны 1 дүгээр сар/**

Улаанбаатар хотын агаарын чанарыг гэр хороолол, автозам, орон сууцны хороолол, үйлдвэрийн дүүрэг орчимд агаар бохирдуулах бодис болох хүхэрлэг хий (SO_2), азотын давхар исэл (NO_2), том ширхэглэгт тоосонцор (PM_{10}), нарийн ширхэглэгт тоосонцор ($\text{PM}_{2.5}$), нүүрстөрөгчийн дутуу исэл (CO), озон (O_3) болон цаг уурын үзүүлэлтүүдийг автомат болон автомат бус багажаар хэмжин тодорхойлж байна.

2017 оны 1 дүгээр сард хэмжигдсэн агаар бохирдуулах бодисын сарын дундаж агууламжийг 2016 оны 1 дүгээр сартай харьцуулахад PM_{10} тоосонцрын дундаж агууламж 3мкг/м^3 -ээр буюу **1%-аар**, $\text{PM}_{2.5}$ тоосонцрын дундаж агууламж 15мкг/м^3 -ээр буюу **8%-аар**, азотын давхар исэл NO_2 -ийн дундаж агууламж 3мкг/м^3 -ээр буюу **5%-аар** тус тус их байсан бол хүхэрлэг хий SO_2 -н дундаж агууламж 19мкг/м^3 -ээр буюу **24%-аар** бага байсан байна. Улаанбаатар хотын 2017 оны 1 дүгээр сарын агаарын чанарыг агаар бохирдуулах бодис тус бүрээр дараах хэсэгт харууллаа.

Том ширхэглэгт тоосонцор (PM_{10})




Зураг 1. Хүйтний улирлын том ширхэглэгт тоосонцрын сарын дундаж агууламж, 2012-2017 он

Агаарын чанарын суурин харуулуудын дүнгээр PM_{10} тоосонцрын 2017 оны 1-р сарын сарын дундаж агууламжийг тооцон гаргахад 228мкг/м^3 байгаа нь өмнөх оны мөн үеийн түвшинд байсан байна. (Зураг 1).

Том ширхэглэгт тоосонцрын 24 цагийн дундаж агууламжийг 2017 оны 1 дүгээр сард нийт 12 цэгт 363 удаа тодорхойлсноос 303 удаад нь буюу 83% нь АЧС дахь ХА-аас давжээ.

1 дүгээр сард 24 цагийн дунджийн хамгийн их агууламж Баянхошуу орчимд 1081мкг/м^3 хүрсэн нь ХА-тай харьцуулахад 10.8 дахин их байна.

Нарийн ширхэглэгт тоосонцор (PM2.5)




Зураг 2. Хүйтний улирлын нарийн ширхэглэгт тоосонцрын сарын дундаж агууламж, 2012-2017 он

Агаарын чанарын суурин харуулуудын дүнгээр PM2.5 тоосонцрын 2016 оны 12-р сарын сарын дундаж агууламжийг тооцон гаргахад 211мкг/м³ байгаа нь өмнөх оноос 8%-аар их байна. (Зураг 2).

Нарийн ширхэглэгт тоосонцрын 24 цагийн дундаж агууламжийг 2017 оны 1 дүгээр сард нийт 7 цэгт 209 удаа тодорхойлсноос 201 удаад нь буюу 96%-д нь АЧС дахь ХА-аас давсан тохиолдол ажиглагджээ. 24 цагийн дунджийн хамгийн их агууламж Баянхошуу орчим 1017мкг/м³ хүрчсэн нь АЧС дахь ХА-тай харьцуулахад 20.3 дахин их байна.

Азотын давхар исэл (NO₂)




Зураг 3. Хүйтний улирлын азотын давхар ислийн сарын дундаж агууламж, 2012-2017 он

Агаарын чанарын суурин харуулуудын дүнгээр азотын давхар исэл NO₂-ийн 2017 оны 1-р сарын сарын дундаж агууламжийг тооцон гаргахад 58мкг/м³ байгаа нь өмнөх оноос 5%-аар их байна (Зураг 3).

Азотын давхар ислийн 24 цагийн дундаж агууламжийг 2017 оны 1 дүгээр сард нийт 13 цэгт 363 удаа тодорхойлсноос 203 удаад нь буюу 56%-д нь АЧС дахь ХА-аас давжээ. 24 цагийн дунджийн хамгийн их агууламж 13-р хороолол орчимд 171мкг/м³ хүрчсэн нь АЧС дахь ХА-тай харьцуулахад 3.4 дахин их байна.

Хүхэрлэг хий (SO_2)



Зураг 4. Хүйтний улирлын хүхэрлэг хийн сарын дундаж агууламж, 2012-2017 он

Агаарын чанарын суурин харуулуудын дүнгээр хүхэрлэг хий SO_2 -ийн 2017 оны 1-р сарын сарын дундаж агууламжийг тооцон гаргахад 61 мкг/м^3 байгаа нь өмнөх оны мөн үеэс 24%-аар бага байлаа. (Зураг 4).


Хүхэрлэг хийн 24 цагийн дундаж агууламжийг 2017 оны 1 дүгээр сард нийт 14 цэгт 400 удаа тодорхойлсноос 245 удаад нь 61%-д нь АЧС дахь ХА-аас давсан тохиолдол ажиглагджээ. 24 цагийн дунджийн хамгийн их агууламж Зурагт орчимд 270 мкг/м^3 хүрсэн нь АЧС дахь ХА-тай харьцуулахад 5.4 дахин их байна.

2017 оны 1 дүгээр сарын агаарын чанарыг индексээр үнэлэхэд


Улаанбаатар хотын агаарын чанарыг хянах зарим суурин харуулуудын 2017 оны 1 дүгээр сарын дүнд индекс тооцон тухайн орчны агаарын чанарыг үнэлэн дараахи хүснэгтэд харууллаа.

Хүснэгт 1. Агаарын чанарын индексийн түвшин, өдрийн тоо

	Цэвэр	Хэвийн	Бага зэргийн бохирдолтой	Дунд зэргийн бохирдолтой	Их бохирдолтой	Маш их бохирдолтой
Нисэх	-	1	6	13	6	3
Толгойт	-	1	-	1	3	25
Баянхошуу	-	1	-	3	3	21
Зурагт	-	-	1	2	9	19
Амгалан	-	2	15	11	2	1
Баруун 4 зам	-	-	11	13	4	3
13-р хороолол	-	1	16	10	2	2
100 айл	-	-	5	8	3	7
Цахилгаан станц	-	3	17	9	1	1
Ургах наран хороолол	1	14	16	-	-	-



Зураг 5. 2017 оны 1-р сарын хоногийн агаарын чанарын индекс агаарын чанарын автомат харуулуудад, %-аар



Зураг 6. Улаанбаатар хотын агаар дахь бохирдуулах бодисуудын агаарын чанарын индекс, 2017 он 1-р сар

ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР
ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТЭС

Хүснэгт 1. 2017 оны 1-р сарын агаарын чанарын индекс

Он, сар, өдөр, гариг		Нисэх	Толгойт	Зурагт	Баянхошуу	100 айл	13-р хороолол	Баруун 4 зам	Амгалан	Цахилгаан станц	Ургах наран хороолол
1/1/2017	Ням	-	434	302	398	-	158	184	166	125	152
1/2/2017	Даваа	-	788	782	1210	-	260	320	342	237	134
1/3/2017	Мягмар	528	868	988	-	-	746	720	596	618	222
1/4/2017	Лхагва	292	794	654	1600	480	234	330	178	128	70
1/5/2017	Пүрэв	342	786	620	1524	448	230	314	206	154	86
1/6/2017	Баасан	430	1078	880	2034	695	312	286	320	319	109
1/7/2017	Бямба	276	710	498	1524	480	174	370	230	170	92
1/8/2017	Ням	230	546	430	408	188	160	264	220	210	116
1/9/2017	Даваа	268	536	416	480	395	196	248	216	231	102
1/10/2017	Мягмар	444	718	598	1132	256	426	422	418	297	161
1/11/2017	Лхагва	570	606	826	-	-	672	510	448	428	196
1/12/2017	Пүрэв	502	696	738	1486	-	414	624	346	331	146
1/13/2017	Баасан	342	604	672	-	561	156	206	138	103	72
1/14/2017	Бямба	192	376	284	374	365	114	234	72	76	61
1/15/2017	Ням	334	558	408	750	269	136	190	208	105	70
1/16/2017	Даваа	384	704	500	1038	400	246	226	276	202	82
1/17/2017	Мягмар	464	824	608	1046	508	354	334	390	275	172
1/18/2017	Лхагва	480	558	512	1558	603	264	308	356	280	140
1/19/2017	Пүрэв	460	840	760	812	345	250	466	400	309	170
1/20/2017	Баасан	258	654	500	1024	736	230	262	304	228	102
1/21/2017	Бямба	270	492	504	694	-	322	414	334	297	146
1/22/2017	Ням	316	470	536	1354	-	264	436	230	148	91
1/23/2017	Даваа	274	-	676	1572	-	220	200	168	108	70
1/24/2017	Мягмар	224	630	542	1348	647	216	208	138	98	56
1/25/2017	Лхагва	140	536	420	442	309	314	308	180	120	70
1/26/2017	Пүрэв	208	512	458	298	103	342	290	234	188	98
1/27/2017	Баасан	300	678	500	956	234	300	334	268	254	127
1/28/2017	Бямба	61	88	152	60	107	54	130	88	80	49
1/29/2017	Ням	194	536	576	636	210	122	216	184	121	64
1/30/2017	Даваа	292	694	622	1074	300	188	224	248	159	84
1/31/2017	Мягмар	420	868	804	1178	698	346	372	398	267	194

Индексийн тоон үзүүлэлт	Агаарын чанар	Эрүүл мэндэд үзүүлэх нөлөөлөл
0 - 50	Цэвэр	Хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл үзүүлэхгүй.
51-100	Хэвийн	Агаарын чанар шаардлага хангах боловч, зарим бохирдуулах бодисын нөлөөлөлд хэт мэдрэг хүмүүс өртөж болно. Тухайлбал, озон, нарийн ширхэглэгт тоосонцрын нөлөөллийн улмаас хэт мэдрэг хүмүүст амьсгалын замын өвчний шинж тэмдэг илрэх магадлалтай.
101 – 250	Бага зэргийн бохирдолтой	Хэт мэдрэг хүмүүсийн эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл илэрнэ. Зүрх судас, амьсгалын замын архаг өвчтэй, ялангуяа гуурсан хоолойн багтраа өвчтэй хүмүүс нөлөөлөлд илүү өртөнө.
251 – 400	Дунд зэргийн бохирдолтой	Нийт хүн амын эрүүл мэндэд бага зэргийн сөрөг нөлөөлөл илэрч эхэлнэ. Хэт мэдрэг хүмүүсийн эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл хүндээр илэрнэ.
401 – 500	Их бохирдолтой	Удаан хугацаагаар гадаа байхад нийт хүн амын эрүүл мэндэд мэдэгдэхүйц нөлөөлөл илэрнэ.
501<	Маш их бохирдолтой	Удаан хугацаагаар гадаа байхад нийт хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл илэрнэ.